## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

2025 оны 12 дугаар сарын 09 Улаанбаатар хот

| № | Агуулга | Зорилго | Зорилт | Арга хэмжээ | Үр дүнтэй (85 буюу түүнээс дээш) | Үр дүн хүлээгдэж байгаа (60-84 хүртэл) | Үр дүн хангалтгүй (30-59 хүртэл) | Үр дүн гараагүй (0-29 хувь) | Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны зохион байгуулалт-20 минутын хотын шилжилт | 3 | 20 | 38 | 32 | 3 | 2 | 1 | | 92.6% |
| 2 | Эко дүүрэг-Ногоон хөгжил | 9 | 54 | 78 | 57 | 8 | 5 | 5 | 3 | 88.1% |
| 3 | Дэд бүтэц-Хот нийтийн аж ахуй | 3 | 16 | 20 | 15 | 2 | 2 | | 1 | 91.6% |
| НИЙТ ДҮН | | 15 | 90 | 136 | 104 | 13 | 9 | 6 | 4 | 90.8% |

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БУЯНТ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.МӨНХГЭРЭЛ

НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН Н.АЛДАРМАА

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 08 — Улаанбаатар хот

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн | | | | | | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг) | | | | | | | |
| | | | | | | | | Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | | |
| **НЭГ. ТӨРИЙН АЛБАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ – 20 МИНУТЫН ХОТЫН ШИЛЖИЛТ** | | | | | | | | | | | | | | | |
| **20 минутын хот** | | | | | | | | | | | | | | | |
| **1.1 Нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлж, иргэд оршин суух буй газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг үе шаттайгаар бүрдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | |
| 1.1.1. Орон нутгийн зэрэглэлтэй “Хан-Уул”, “Яармаг”, “Буянт-Ухаа” хотууд шинээр байгуулах зохион байгуулалтын бэлтгэл ажлыг талуудын оролцоотойгоор хангана. | 1 | Орон нутгийн зэрэглэлтэй хот байгуулахад шаардагдах бэлтгэл ажлыг үе шаттайгаар хамтран зохион байгуулах (МУЗГҮАХ-1.1.1.1-4) | 2025-2028 | Бэлтгэл ажлын хэрэгжилтийн хувь | - | 30% | | | | | | | | “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын бэлтгэл ажлын хүрээнд хуулиар хүлээсэн чиг үүргийн судалгааг Хууль, эрх зүйн хэлтэс, бүтэц, орон тооны судалгааг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, зардлын тооцооллын судалгааг Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн тасагтай хамтран тус тус гаргаж, мэдээллийг загвар хүснэгтийн дагуу нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 100.0% |
| 1.1.2. Хороодыг нэгтгэн зохис байгуулж 120 мянгат, Зайсан, Ээрмэл, Яармаг, Арцат, Буянт-Ухаа орчмыг хорооллын зохион байгуулалтад шилжүүлэх бэлтгэл хангана. | 2 | Хороодыг нэгтгэн хорооллын зохион байгуулалтад шилжүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг үе шаттайгаар хамтран зохион байгуулах | 2025-2027 | Бэлтгэл ажлын хэрэгжилтийн хувь | - | 30% | | | | | | | | “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын бэлтгэл ажлын хүрээнд судалгаа, мэдээллийг гаргаж нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Үүнд;<br>Чиг үүргийн шинжилгээгээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулиар одоо мөрдөгдөж байгаа нийслэлийн нийт 49 чиг үүргээс шинээр байгуулагдах хотод 37, хороололд 30, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн одоо мөрдөгдөж байгаа нийслэлийн нийт 22 чиг үүргээс шинээр байгуулагдах хотод 10, хороололд 21, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн одоо мөрдөгдөж байгаа нийслэлийн нийт 30 чиг үүргээс шинээр байгуулагдах хотод 30 чиг үүрэг тус тус шилжих боломжтой.<br>Бүтэц, орон тооны судалгааг одоогийн батлагдсан Засаг даргын Тамгын газрын 100, хорооны 100 болон 270 хэсгийн ахлагч, нийт 470 орон тоог 3 хот, 8 хороололд дараах байдлаар хуваарилан байршуулсан. Үүнд;<br>-Хан-Уул хотод удирдлага 3, 7 хэлтэст 47, нийт 50 албан хаагчтай, 4 нэгж хороолол тус бүрд удирдлага 3, 3 хэлтэс, 1 тасаг 35-36, нийт 154 буюу 204 албан хаагч;<br>-Яармаг хотод удирдлага 3, 7 хэлтэст 45, нийт 48 албан хаагчтай, 2 нэгж хороолол тус бүрд удирдлага 3, 3 хэлтэс, 1 тасаг 35-36, нийт 77 буюу 125 албан хаагч;<br>-Буянт-Ухаа хотод удирдлага 3, 7 хэлтэст 45, нийт 48 албан хаагчтай, 2 нэгж хороолол тус бүрд удирдлага 3, 3 хэлтэс, 1 тасаг 35-36, нийт 77 буюу 125 албан хаагч;Нийт 3 хот, 8 хороололд 454, зайлшгүй нэмэгдэх шаардлагатай 26, нийт 470 төрийн албан хаагч, хэмнэгдсэн орон тоо нь Баянгол дүүргээс Хан-Уул хотод шилжин ирэх хорооны албан хаагчийн орон тоо.<br>Зардлын тооцооллын судалгаагаар 9 төрлийн тавилга 1278, 5 төрлийн тоног төхөөрөмж 472, нийт 1750 ширхэг тавилга, тоног төхөөрөмжөөр 470 төрийн албан хаагчийг хангах боломжтой. | 100.0% |
| 1.1.3. Шинээр байгуулагда орон нутгийн зэрэглэлтэй “Хан-Уул”, “Яармаг”, “Буянт-Ухаа” хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн чиг үүргийн байгууллагуудтай хамтран боловсруулна. | 3 | Шинээр байгуулагдах орон нутгийн зэрэглэлтэй хотын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах МУЗГҮАХХАХТ-1163 | 2026-2028 | Хэрэгжилтийн хувь | - | 10% | | | | | | | | Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан Монгол улсын Их хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 14 орон нутгийн зэрэглэлтэй хот болгохоор шийдвэрлэсэн.<br>Тус тогтоолын хэрэгжих хугацааг Улсын Их Хурлын 2025 оны 46 дугаар тогтоолоор 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр өөрчлөлт оруулсан.<br>Хан-Уул дүүргийн хувьд Буянт-Ухаа хот, Хан-Уул хот, Яармаг хот болон хуваагдахаар төлөвлөгдсөн бөгөөд 20 минутын хот үндэсний хороонд шинээр байгуулагдах хот, нэгжүүдийн бүтэц, чиг үүргийн хуваарилалтын судалгаа, танилцуулгыг боловсруулж, “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн бэлтгэл ажил, 20 минутын хот стандартыг хангуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсэгт хүргүүлсэн. | 100.0% |
| 1.1.4. Анхан шатны нэгжид чиг үүргийг шилжүүлэх замаар иргэдээс нийтлэг гардаг санал, хүсэлт, гомдлыг шууд бие даан шуурхай шийдвэрлэх зохион байгуулалтад шилжинэ. | 4 | Иргэдээс гардаг нийтлэг санал, хүсэлт, гомдлыг шууд бие даан шуурхай шийдвэрлэх бүтэц, орон тоо, чиг үүргийн санал боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах | 2025 | Боловсруулсан бүтэц орон тоо, чиг үүргийн саналын баримт бичиг, өссөн дүнгээр | - | 1 | 20.0 | | | | | | | “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын бэлтгэл ажлын хүрээнд хийсэн судалгаагаар анхан шатны нэгж болох хороодыг нэгтгэн нэгж хороололд шилжүүлэхэд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан нийслэлийн 49 чиг үүргээс шинээр байгуулагдах хороололд 30, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийслэлийн 22 чиг үүргээс шинээр хороололд 21 чиг үүрэг тус тус шилжих боломжтой байна. Дээрх 2 хуулийн хүрээнд нийт 51 чиг үүрэг анхан шатны нэгжид шилжин ирснээр иргэдээс нийтлэг гардаг санал, хүсэлт, гомдлыг шууд бие даан шуурхай шийдвэрлэх боломж бүрдэх талаар судалгаа гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 100.0% |
| 1.1.5. Өрхийн эмнэлгүүдийн зарим зохион байгуулалтуудыг нэгтгэж хороолол бүрд **“Эрүүл мэндийн төв”** байгуулах ажлыг талуудтай хамтран үе шаттай зохион байгуулна. | 5 | Иргэд оршин суух газраасаа эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах | 2025-2028 | Бэлтгэл ажлын хэрэгжилтийн хувь | - | 10% | | | | | 2,569.2 | | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 8, 10 дугаар хороонд 2 өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барьж, 24 дүгээр хороонд шинээр 249 м.кв талбай бүхий өрхийн эрүүл мэндийн байрыг худалдан авч, иргэдэд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг ойроос авах боломжийг бүрдүүлж байна. | 100.0% |
| | 6 | Эмнэлгийн барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | 2024-2028 | Нэмэгдсэн эмнэлгийн барилга байгууламжийн тоо | 28 | 3 | 2,537.2 | | | | 2,537.2 | | | Эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр 3 төсөл арга хэмжээг 2025 онд он дамжуулан хэрэгжүүлснээс 2 барилга ашиглалтад орж, 1 барилга улсын комисс ажиллах шатанд байна.<br>Ажлын явцаар авч үзвэл:<br>- Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Жи Би Ти Эм Би" ХХК ажиллаж, 200 м.кв талбай бүхий барилгыг ашиглалтад оруулсан.<br>-Өрхийн эрүүл мэндийн төвийн байр худалдан авах (24 дүгээр хороо) төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Л.Оггогүй шалгарч, 249 м.кв талбай бүхий байрыг эмнэлгийн зориулалтаар засварлаж, ашиглалтад хүлээлгэж өгсөн.<br>-Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024-2025 онд дамжин хэрэгжиж буй 10 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг Элбэг гүн ХХК гүйцэтгэж, 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлт өгсөн. Улсын комисс ажиллах шатанд хэрэгжиж байна. | 100.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн | | | | | | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг) | | | | | | | |
| | | | | | | | | Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | | |
| | 7 | Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулах | 2024-2027 | Барилгын ажлын явц | 10% | 40% | | | | | | | | Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр болон зээлийн гэрээний дагуу Хан-Уул дүүргийн 23 дугээр хороонд Нэгдсэн эмнэлгийн гадна 11545 м.кв цэвэр талбай бүхий төмөр бетон цутгамал хийцлэлтэй, зоорийн давхраас гадна 4 давхар, 200 ор, 250 машины зогсоол, байгальд ээлтэй, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах технологи бүхий эмнэлгийн барилгын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 34.5 сая долларын санхүүжилттэй барилга угсралтын ажлаас гадна 7,8 сая долларын санхүүжилтээр 64 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээ явуулахад зайлшгүй шаардлагатай тавилга, хэрэгслүүд нийлүүлэгдэхээр тусгагдсан. | 100.0% |
| 1.1.6. Төрийн цахим үйлчилгээний **“Хурдан цэг”**-үүдийг иргэдэд ойрхон хүртээмжтэй байх зохион байгуулалт хийж ажиллуулна. | 8 | Төрийн цахим үйлчилгээний "Хурдан" цэгийн тоог нэмэгдүүлэх | 2026-2028 | 24/7 "Хурдан" цэгийн тоо | | 1 | 20.0 | | | | | | | Хан-Уул дүүргийн хэмжээнд 60 байгууллагын 600 гаруй үйлчилгээ үзүүлдэг "Гэрэгэ-Хурдан" киоск 40 байршилд 76 машин ажиллаж байна. Үүнээс дүүргийн 15 хороо "Тара центр" худалдааны төв болон 24-р хороо "Белмонте" хотхоны 1 давхарт 24 цагаар ажиллаж байна. Төрийн үйлчилгээний “24/7” цэгийг нээж ажиллуулах байршлын судалгааг хорооны 58 албан хаагч, 90 иргэнээс цахим хэлбэрээр авсан. Иргэд, албан хаагчдын дийлэнх хувь дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд “24/7” цэгийг нээхээр санал өгсөн ба төсвийн хязгаарлалтын улмаас хойшлогдсон. 2026 оны төсөвт суулгахаар судалгааг хийж санал хүргүүлсэн байна. | 80.0% |
| 1.1.7. Хорооллын нутаг дэвсгэрийн аль ч цэгт цагдаагийн байгууллага дуудлага хүлээн авснаас хойш **20** минутад автомашинаар очих, хүртээмжтэй байх зохион байгуулалтыг цагдаагийн байгууллагатай хамтран шат дараатайгаар хийнэ. | 9 | 25 хорооны нутаг дэвсгэрт байрлах цагдаагийн хэсгийн байцаагч нарын албан өрөө /цагдаагийн хэсэг байр/-нд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, автомашинаар хангах | 2025-2028 | Хороодод хүлээлгэн өгсөн автомашины тоо | 26 | 15 | 1,335.0 | | | | | | | 1.Хоёрдугаар хэлтсийн дотоод болон гадна тал, мэдүүлэг авах өрөөний ширээнүүд, галт зэвсэг, архив, авто граш, эд мөрийн баримт хадгалах өрөөнд нийт 50 ширхэг телекамер, хяналтын 3 дэлгэц, 80 хоног бичлэг хадгалах хүчин чадал бүхий NVR төхөөрөмж, HDD, кабелийн сувагчлалыг “Агт буян” ХХК-иар бүрэн суурилуулах ажлын 19.810.000 төгрөгийг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс,<br>2.Тус цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны стандарт шаардлагад нийцүүлж үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай зардлын 19,613,000 төгрөгийн санхүүжилтийг Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын энэ оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/64 дугаартай захирамжаар,<br>3.Цагдаагийн байгууллагын шалгаж буй зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийн баазыг сайжруулах ажилд шаардагдах зардлын 50,868,300 төгрөгийг Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын энэ оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/67 дугаартай захирамжаар тус тус шийдвэрлүүлсэн.<br>4. Дүүргийн цагдаагийн газар, хэлтсүүдийн жижүүрийн шуурхай удирдлагын өрөө болон иргэдэд зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх зорилгоор 100 сая төгрөгийг шийдвэрлүүлж,эхний ээлжинд шинээр томилогдсон мөрдөгч нарт зориулж, 6 ширхэг иж бүрэн компьютер, принтер, 3 зөөврийн компьютерийг шийдвэрлэсэн. | 100.0% |
| 1.1.8. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд багачууд оршин суугаа газраасаа **20** минутын зайд боловсролын үйлчилгээ авах боломжийг үе шаттайгаар бүрдүүлнэ. | 10 | Шинээр сургуулийн барилгыг барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх (МУЗГҮАХХТ-317) | 2024-2028 | Ашиглалтанд орсон сургууль/суудлын тоо | 23/19348 | 3/2000 | 32,517.4 | 3,970.0 | 40,873.3 | | 11,940.6 | | | Хан-Уул дүүрэгт 2024-2025 онд нийт 8560 хүүхдийн суудалтай 12 сургууль баригдахаар төлөвлөгдсөнөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус бүр 640 суудалтай 15 дугаар сургуулийн өргөтгөл, 8 дугаар хорооны сургуулийн барилга, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16 дугаар хорооны 640 суудалтай сургуулийн барилга тус тус ашиглалтад орж, сургуулийн хүчин чадлыг 1920 суудлаар нэмэгдүүлсэн.<br>Гүйцэтгэлийн шатанд хэрэгжиж буй 9 сургуулийн барилгын ажлын явцыг санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэлээр авч үзвэл:<br>1.Бүгд Найрамдах Энэтхэг улсын буцалтгүй тусламжаар;<br>□22 дугаар хороонд хэрэгжиж буй 1200 суудалтай сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 60%, гүйцэтгэгч "Буянт шарга" ХХК<br>2.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр;<br>□4 дүгээр хороонд 960 суудалтай барилгын гадна фасад, дотор заслын ажил дуусах шатанд, 85 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч Ай Ди Си проперти ХХК<br>□23 дугаар хороонд 960 суудалтай сургуулийн барилгын 3 давхрын карказ цутгалт, дүүргэлтийн ажил дууссан, ажлын явц 40%, гүйцэтгэгч Хуягт харш ХХК,<br>□17 дугаар хороонд 960 суудалтай сургуулийн барилгын карказ угсралт дууссан, ажлын явц 50%,гүйцэтгэгч "Гурван булаг сод" ХХК,<br>□18 дугаар хороонд 640 суудалтай барилгын ажил зураг төсөл магадлал хийгдэх шатанд хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Гантоонот констракшн" ХХК<br>□23 дугаар хороонд 63 дугаар сургуулийн өргөтгөл 480 суудалтай сургуулийн барилгын 1 дүгээр давхрын каркас угсрах шатанд, 35 хувийн гүйцэтгэлтэй. Гүйцэтгэгч Гурван тахилгат оргил ХХК<br>3.Дүүргийн төсвийн хөрөнгөөр;<br>□3 дугаар хороонд хэрэгжих 480 суудалтай сургуулийн барилгын ажил зураг төсөл магадлал хийгдэх шатанд хэрэгжиж байна. Гүйцэтгэгч Вишн девелопмент ХХК,<br>□16 дугаар хороонд хэрэгжих 7 дугаар сургуулийн барилгыг буулгаж, 480 суудалтай сургууль барих ажлын зураг төсөл магадлал хийгдсэн. Гүйцэтгэгч Гранд марз ХХК,<br>□14 дүгээр хороонд хэрэгжих 59-р сургуулийн 480 суудалтай өргөтгөлийн барилгын ажил гүйцэтгэгч шалгаруулах шатанд байна. | 100.0% |
| | 11 | Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгыг шинээр ашиглалтад оруулах | 2024-2026 | Ашиглалтанд орсон бага сургууль, цэцэрлэгийн тоо, суудал, орны тоо | 3/540 суудал, 300 ор | 6 барилга, 1080 суудал, 600 ор | 11,004.4 | 5,698.3 | 12,654.8 | | | | | Хан-Уул дүүргийн 8, 9, 12, 14, 16, 24 дүгээр хороонд 1260 суудал, 700 орны хүчин чадалтай 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажил хэрэгжиж байгаагаас 12, 14, 16, 24 дүгээр хороонд баригдсан 4 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга ашиглалтад орсон.Он дамжин хэрэгжиж байгаа бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгыг санхүүжилтийн эх үүсвэр, явцыг авч үзвэл:<br>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар хороонд 180 суудал, 100 орны хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Хаш гоёо" ХХК<br>2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороонд 180 суудал, 100 орны хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Шунхлайн шандас" ХХК<br>3.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороонд 180 суудал, 100 орны хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажил 90 % гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Жавхлант тур" ХХК | 100.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн: Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг): Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 12 | Шинээр цэцэрлэгийн барилгыг барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх (МУЗГҮАХХТ-315) | 2024-2028 | Ашиглалтанд орсон цэцэрлэг/ орны тоо | 41/15850 | 10/1800 | 20,025.9 | | 6,811.4 | | 10,865.6 | | | Хан-Уул дүүрэгт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 1835 орны хүчин чадалтай 13 цэцэрлэг барилга ашиглалтад оруулахаар төлөвлөгдсөнөөс 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр 270 ортой 67, 71 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл, 1 дүгээр хороонд 240 ортой цэцэрлэгийн барилга, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15, 23 дугаар хороонд нийт 445 ортой 4 цэцэрлэгийн барилга, дүүргийн төсвийн хөрөнгөөр 20 дугаар хороонд 100 ортой цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орж, цэцэрлэгийн хүртээмжийг 1055 ортой 8 барилгаар нэмэгдүүлсэн.<br>Он дамжин хэрэгжиж буй цэцэрлэгийн барилгуудыг санхүүжилтийн эх үүсвэр, явцаар авч үзвэл:<br>1. Улсын төсвийн хөрөнгөөр 18 дугаар хороонд хэрэгжих 200 ортой цэцэрлэгийн барилга эдэлбэр газрын хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан зураг төсвийг өөрчилж, боловсруулж байна. Гүйцэтгэгч Юувоку ХХК<br>2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд хэрэгжиж буй 240 ортой цэцэрлэгийн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгчээр "Жинст цамхаг" ХХК<br>3. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9 дүгээр хороонд хэрэгжиж буй 100 ортой цэцэрлэгийн барилгын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Инерци" ХХК, "Таван од констракшн" ХХК<br>4.Дүүргийн төсвийн хөрөнгөөр 23 дугаар хороонд хэрэгжиж буй 240 ортой цэцэрлэгийн барилгын ажил зураг төсөл магадлал хийгдэх шатанд хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Төгсбаялаг алтай" ХХК | 100.0% |
| | 13 | Сургууль, цэцэрлэгүүдийн шаардлагатай барилга байгууламжийг засварлах, инженерийн шугам сүлжээг засварлах, төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлэх | 2024-2028 | Засварласан сургууль, цэцэрлэгийн барилгын тоо | - | 8 | 1,600.0 | | 2,640.0 | | 779.5 | 437.8 | | Нийслэлийн төсвийн 1,194.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжих 53, 165, 250, 35 дугаар цэцэрлэг, 18, 59, 156, 89 дүгээр сургуулийн дээвэр засварын ажлын гүйцэтгэгчээр "Очир шүр" ХХК шалгарсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар гэрээ байгуулагдаагүй, 2026 онд хэрэгжинэ.<br>Нийслэлийн төсвийн 1,445.9 сая төгрөгийн хөрөнгөөр 65, 209, 190, 218, 41 дүгээр цэцэрлэгийн шугамын засвар, 60 дугаар сургуулийн спорт заал, 26 дугаар сургуулийн урлаг заалын засвар, 114 дүгээр сургуулийн цэвэр, бохир усны шугамын засварын ажлыг "Очир шүр" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 209, 190 дүгээр цэцэрлэгийн шугам засвар, 60 дугаар сургуулийн спорт заалны засварын ажлууд хэрэгжиж дууссан.<br>Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 1,217.3 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжих 2 төсөл арга хэмжээний хүрээнд 4, 5, 7, 8 дугаар хороо, 60, 41 дүгээр сургууль, 12, 34, 29, 71, 73, 145 дугаар цэцэрлэгүүдийг бохир усны төвлөрсөн шугамд холбох ажил худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. | 50.0% |
| Шаардагдах төсөв | | | | | | | 69,059.9 | 9,668.3 | 62,979.5 | - | 28,692.1 | 437.8 | - | | |
| **Төрийн үйлчилгээ**<br>**1.2 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | | | | | | | | | |
| 1.2.1 Хүний нөөцийн бодлого чиглэлийн хүрээнд төрийн албан хаагчдын "Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 14 | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах | 2025-2028 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90.4 | 90 | 25.0 | | | | | | | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/15 дугаар тушаалаар “Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Сургалт, хөгжлийн 2025 оны нэгдсэн төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан. Төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ тусгагдсанаас, бүрэн хэрэгжсэн 14 арга хэмжээ, хэрэгжилт дутуу 1, арга хэмжээ, хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээ байна. | 100.0% |
| | 15 | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах | | Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 90.4 | 90 | 100.0 | | | | | | | Тайлант хугацаанд ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшил, тогтвор суурьшилтай ажилласан байдал, амьдралын нөхцлийг харгалзан 38 албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг 100% зохион байгуулсан бөгөөд дэмжлэгт хамрагдсан төрийн захиргаа, төрийн тусгай болон үйлчилгээний 38 албан хаагчтай “Хариуцлагын гэрээ” байгуулсан. | 100.0% |
| 1.2.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчдыг авлигын эрсдэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | 16 | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах | 2025-2028 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 96 | 90 | 30.0 | | | | | | | Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр батлуулж төлөвлөгөөнд Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлээр 3, дэд хорооны хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр 3, үйл ажиллагааг тайлагнах мэдээлэх чиглэлээр 3, нийт 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, төлөвлөгөөний жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн. | 100.0% |
| | 17 | Авлигын эсрэг үйл ажиллагааны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах | 2025-2028 | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90 | 90 | 10.0 | | | | | | | Төрийн албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, байгууллагын ил тод байдлыг сайжруулах, Хан-Уул дүүргийн хэмжээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр 2025 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг тусган Засаг даргаар батлуулсан бөгөөд тайлант хугацаанд төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн. | 100.0% |
| 1.2.3 Төрийн байгууллагуудын барилга байгууламж, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангах ажлыг хэрэгжүүлнэ. | 18 | Төрийн байгууллагуудын шаардлагатай барилга байгууламжийг засварлан, техник тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангаж, ажиллах нөхцөлийг сайжруулах | 2025-2028 | Хэрэгжсэн төсөл арга хэмжээний тоо | 8 | 2 | 160.0 | | | | 697.6 | | | Төрийн байгууллагын үйлчилгээний хүртээмж, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1.Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийг 15 ширхэг иж бүрэн суурин компьютер, 11 ширхэг олон үйлдэлт принтер, 4 ширхэг түргэн сканнер зэрэг тоног төхөөрөмжөөр хангасан. Гүйцэтгэгч "Ай ти зон" ХХК<br>2.Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг Багц-1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр "Сод буян констракшн" ХХК шалгарч 31 ширхэг тоног төхөөрөмж, 113 ширхэг тавилга, эд хогшил, Багц-2 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр "Анун" ХХК шалгарч, 96 ширхэг тавилгыг хүлээлгэн өгсөн.<br>3.Төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин худалдан авах ажлын гүйцэтгэгчээр “Эмбб роуд транс” ХХК шалгарч, албаны хэрэгцээ шаардлагыг үндэслэн Цэргийн штаб, 8, 16 дугаар хороо, Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ тус бүр 1 ширхэг приус 41 авто машин, дүүргийн Засаг даргын тамгын газарт 1 ширхэг тоёота велфайр, 1 ширхэг приус 41 автомашин, Соёлын ордонд 1 ширхэг тоёота велфайр, нийт 7 авто машин тус тус хүлээлгэн өгсөн. | 100.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн | | | | | | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг) | | | | | | | |
| | | | | | | | | Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | | |
| 1.2.4 Төрийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, үйлчилгээг цахимжуулахад дэмжлэг үзүүлнэ. | 19 | Хот нийтийн аж ахуйн чиг үүргийг хувийн байгууллагаар гүйцэтгүүлэхэд анхаарч нэмэгдүүлэх арга хэмжээ авах. | 2025-2028 | Хэрэгжилтийн хувь | 36.9 | 21.7 | 13,792.0 | | | | | | | Дүүргийн Иргэдийн Төлөөлөлгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор, Хот нийтийн аж ахуйн чиг үүргийг хувийн байгууллагаар гүйцэтгүүлэх зардалд өөрчлөлт оруулж батлуулсан. 15,997.4 сая төгрөгийн санхүүжилтийг хянан, гүйцэтгэгч байгууллагуудад олгосон. | 100.0% |
| | 20 | Хот нийтийн аж ахуйн чиг үүргийн ажлын гүйцэтгэлийн хяналтыг цахим хэлбэрт шилжүүлнэ. | 2025-2028 | Хэрэгжилтийн хувь | 10 | 30 | 10.0 | | | | | | | Дүүргийн зам талбайн цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийг хяналтын цахим системийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, зам талбайн цэвэрлэгээ хариуцсан 14 байгууллага, хог тээвэрлэлт хариуцсан 4 байгууллагын сарын гүйцэтгэлийг хяналтын системийн үнэлгээний дагуу олгосон. | 100.0% |
| | 21 | Зарим нэр төрлийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах МУЗГҮАХХАХТ-1120 | 2025-2028 | Хэрэгжилтийн хувь | - | 20 | 10.0 | | | | | | | Төрийн албан хаагчтай холбоотой судалгаа, мэдээллийг нэгтгэн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бий болгож байгууллагын дотоод үйл ажиллагаа болон хүний нөөцийн ил тод байдлыг хангуулахаар Power BI программд төрийн албан хаагчдын мэдээллийг оруулж дашбоард үүсгэсэн.<br>Хан-Уул дүүргийн албан ёсны вэбсайт болох “Khanuul.mn”-ийг шинэчлэхээр 5 дугаар сарын 14-ний өдөр “Эрасад Прожект” компанитай гэрээ байгуулсан. Шинэчлэлтийн ажлыг 11 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.<br>Мөн Вэб сайтын шинэчлэлийн хүрээнд чатбот үйлчилгээ нэвтрүүлэх бөгөөд энэ нь иргэдээс хамгийн их давтагддаг асуултуудын хариуг автомат байдлаар, түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр иргэдэд мэдээлэл авах үйл явц хялбар болж, үйлчилгээний хүртээмж, үр ашигтай байдал сайжирна. | 80.0% |
| 1.2.5 Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. | 22 | Харьяа байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах | 2025-2028 | Хэрэгжилтийн хувь | 0 | 30 | 2.0 | | | | | | | Хан-Уул дүүргийн хэмжээнд Засаг даргын Тамгын газар Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” программ ашиглан Захирамжлалын 40 баримт бичгийн төслийг 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 9 сарын хугацаанд цахимаар боловсруулах ажлыг туршилтын журмаар хэрэгжүүлсэн. Нийслэлийн архивын газраас хөгжүүлэлт хийгдээгүй, программын ачаалал ихэссэн тул цахимжуулах ажлыг хойшлуулаад байна. | |
| 1.2.6. Төрийн архивын **“Салбар архив”** байгуулах ажлыг эхлүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 23 | “Төрийн архивын салбар архив” байгуулах ажлыг үе шаттайгаар эхлүүлэх | 2025-2028 | Хэрэгжилтийн хувь | - | 20 | 5.0 | | | | | | | Дүүрэг дэх Төрийн архивын хадгаламжийн нэгжид хадгалагдаж буй баримтад Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/41 дүгээр тушаалаар 2025 оны 03 дугаар сарын 29-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрийн хооронд баримтын тооллого зохион байгуулсан. Тооллогоор дүүргийн архивын 1964-2023 оны 13853 хадгаламжийн нэгж, байгууллагын архивын 1964-2023 оны 4394 хадгаламжийн нэгжид тус тус тооллого хийж илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь засварласан. | 100.0% |
| 1.2.7. Дүүргийн салбар архив болон Засаг даргын Тамгын газрын архивт хадгалагдаж буй цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ. | 24 | Төрийн архивт хөмрөг үүсгэгч 13 хорооны малын А дансны 171 баримтыг цахимжуулах | 2025-2028 | Хэрэгжилтийн хувь | 0 | 20 | 3.5 | | | | | | | Хан-Уул дүүргийн Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй 4 дүгээр хорооны Малын А дансны 1998-2017 оны 10 хадгаламжийн нэгжийн 239 хуудас бүхий баримтыг цахимжуулан хөмрөг үүсгэсэн. | 50.0% |
| Шаардагдах төсөв | | | | | | | 14,147.5 | - | - | - | 697.6 | - | - | | |
| **Олон нийтийн аюулгүй, амар тайван байдал**<br>**1.3.Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | |
| 1.3.1. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн камерын хяналтыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны камерыг **"Телехяналтын камерын дэд төв"**-д холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 25 | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн камерын засвар, арчлалтыг сайжруулах | 2025-2028 | Засвар арчлалтын хяналтад авсан камерын тоо | 1230 | 1230 | 1,000.0 | | | | 953.8 | | | Хан-Уул дүүргийн хэмжээнд 2025 оны эхэнд аж ахуйн нэгж байгууллагын 7876, улсын төсвийн хөрөнгө оруулалттай 1330, нийт 9206 камер байсан.<br>Үүнээс нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хороодод төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан 1330 камерын засвар үйлчилгээг Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ бүрэн хариуцаж байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар 20 байршилд 190 камер засварлаж, 10 байршилд 87 камер шинээр суурилуулснаар 1417 камер ажиллаж байна. | 100.0% |
| | 26 | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн теле хяналтын камерын тоог нэмэгдүүлэх | 2024-2028 | Нэмэгдсэн камерын тоо | 255 | 400 | 1,604.5 | | | | 1,032.8 | 774.6 | | Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 3,325.8 сая төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 5 төслийн хүрээнд 144 цэгт 371 камер суурилуулж, телекамерын хяналтын дэд төвд холбох ажил 50-100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Тухайлбал:<br>1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Инносолюшн" ХХК 1,2,3,6,8,17,19,20-р хороодын 24 цэгт чиглэлийн 53 камер, дүүргийн төсвийн хөрөнгөөр Сонголт нар ХХК 10,12,13,14,21,25-р хороодын 5 цэгт түгээмэл тархацтай ашигт малтмалын тээвэрлэлтийг хянах 10 камер суурилуулж, ашиглалтад оруулсан.<br>2.Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Арш технологи ХХК-ийн 1,2,3,4,5,9,10,11,13,14,15,16,17,18,19,20,21-р хороодын 37 цэгт нийт 114 ширхэг чиглэлийн камер, 5 ширхэг хөдөлгөөнт камер, Инносолюшн ХХК 5,6,8,9,10,12,13,14,21,25-р хороодын 40 цэгт нийт 80 ширхэг чиглэлийн камер суурилуулах ажлууд тус бүр 90 хувьтай хэрэгжиж байна. Жилийн эцсийн байдлаар нийтийн эзэмшлийн 29 цэгт 63, 10 байршилд 87, нийт 150 камер шинээр суурилуулснаар 1480 камер хэвийн ажиллаж байна. | 100.0% |
| | 27 | “Телехяналтын камерын дэд төв"-ийг ашиглалтад оруулах (МУЗҮАХХТ-54) | 2025 | Хэрэгжилтийн хувь | 70% | 100% | | | | | 73.0 | | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай мэдээлэл дамжуулах, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор 1500 хүртэл камер хянах хүчин чадал бүхий сервертэй Телекамерын хяналтын дэд төв Хан-Уул дүүргийн 16 дугаар хороонд 2025 оны 6 дугаар сард ашиглалтад орсон.<br>Жилийн эцсийн байдлаар Телекамерын хяналтын дэд төвд 178 камер бүрэн холбогдсон бөгөөд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Арш технологи ХХК, “Камерын хяналтын нэгдсэн төв, камержуулалтын ажил” төслийн хүрээнд 16, 21, 25-р хороодын 38 цэгт 108 ширхэг чиглэлийн, 1 ширхэг хөдөлгөөнт камер суурилуулах ажил 50 хувьтай хэрэгжиж байна. Цаашид Нийтлэг үйлчилгээний алба хариуцаж буй 1241 камерыг үе шаттай холбох ажлууд хийгдэнэ. | 100.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн | | | | | | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг) | | | | | | | |
| | | | | | | | | Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | | |
| 1.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх илрүүлэх чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | 28 | Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | 2024-2028 | Арга хэмжээний тоо | - | 2 | | | | | | | | Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх албаны 5 чиглэл, 28 арга хэмжээ, дүүргийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зүйн салбар зөвлөлийн 4 чиглэл, 23 арга хэмжээтэй уялдуулан Цагдаагийн газрын 2025 оны төлөвлөгөөнд дүүргийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 4 чиглэл 18 арга хэмжээтэй төлөвлөн батлуулан 4 сургалт, 1 өдөрлөг, 3 удаагийн эргүүл хяналт зохион байгуулан нийт 6452 хүүхэд хамруулж, 90%-тай хэрэгжүүлсэн.<br>Мөн эхний 8 сарын байдлаар нийт 1914 гэмт хэрэг бүртгэгдсэнээс залилах гэмт хэрэг 729, үүнээс цахим орчинд залилах гэмт хэрэг 402 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 40 хувь цахим орчинд үйлдэгдсэн хэргийн 55 хувийг залилах гэмт хэрэг эзэлж байсан. Үүнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх албатай хамтран “Эко Хан-Уул дүүргийн иргэд цахим залиланд өртөхгүй” арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдрөөс 10 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл нэг сарын хугацаатай зохион байгуулснаар цахим залилангийн шинжтэй гомдол 59 бүртгэгдэж 72 нэгжээр буюу 50 хувь, бусад залилах гэмт хэргийн шинжтэй гомдол 21 бүртгэгдэж 21 нэгжээр буюу 50 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Цахим орчинд үйлдэгдэж байгаа “Залилах” гэмт хэрэг 104 нэгж буюу 79,3% буурсан нь 1 мөрдөгчид оногдох ажлын ачаалал 25-30% буурсан. | 100.0% |
| | 29 | Алсын хороодод цагдаагийн кобан байгуулах | 2024-2028 | Ашиглалтад өгсөн кобаны тоо | | | | | | | | | | Тус цагдаагийн газрын хариуцсан алслагдсан хороодод цагдаагийн кобан байгуулах санхүүжилт төсөвт тусгагдаагүй.<br>Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо 5 давхар байрны 1 давхар 3 өрөө 65мкв Био дахь хэсгийн байрыг засварын зардалд шаардагдах 12.000.000 сая төгрөгийг шийдвэрлүүлэх хүсэлтийг Засаг даргад хүргүүлж засварын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. | 10.0% |
| 1.3.3. Иргэд, олон нийтэд хүргэх гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | 30 | Гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг олон нийтэд хүргэх ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах | 2024-2028 | Арга хэмжээний тоо | 17 | 12 | 2.0 | | | | | | | Болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюул, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан урьдчилан сэргийлэх чиглэлээр Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс фэйс хуудсанд 189 удаагийн постер, 24 удаагийн видео, сэрэмжлүүлэг, цаг үеийн шинжтэй 49 удаагийн мэдээлэл, www.gov.mn/mn/organization/-Khan-Uul-District сайтад 22 мэдээ нийтэлсэн. Үүнээс гадна Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Онцгой байдлын газраас гаргасан 443 удаагийн постер, 262 мэдээ мэдээллийг олон нийтэд цахимаар түгээсэн. | 100.0% |
| | 31 | Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулах МУЗГҮАХХАХТ-1383 | 2024-2028 | Сургалтанд хамрагдагсдын тоо | 361 | 230 | 0.5 | | | | | | | Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг 8 удаа 644 ажилтанд, төрийн болон төрийн бус байгууллага, удирдах албан тушаалтны сургалтыг 3 удаа 58 албан тушаалтанд, аж ахуй нэгжийн ажилтан, алба хаагчын сургалтыг 145 удаа 4164 ажилтан алба хаагчдад, иргэний сургалтыг 13 удаа 153 иргэнд, их дээд сургуулийн сургалтыг 1 удаа 29 оюутанд, Ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг 56 удаа 6820, сургуулийн өмнөх боловсролын сургалтыг 42 удаа 1254 ажилтан алба хаагчдад зохион байгуулсан. Тайлант хугацаанд нийт 268 удаа 13122 иргэн, ажилтан алба хаагч сурагчдыг хамруулан тус тус зохион байгуулсан. | 100.0% |
| | 32 | Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулах МУЗГҮАХХАХТ-1376 | 2024-2028 | Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо | 2 | 1 | 60.0 | | | | 29.0 | | | Хан-Уул дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 29.0 сая төгрөгөөр Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах ангиудад:<br>1. Лайв төхөөрөмж-1,<br>2. Зөөврийн чанга яригч-1,<br>3. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж-3, нийт 3 төрлийн 5 тоног, хэрэгслийг худалдан авч, 2025 оны 06 дугаар сарын 06-нд хүлээлгэн өгсөн.<br>Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлөөс ой хээрийн түймрийн үед ашиглах зориулалт бүхий 15 ширхэг рло, 6 ширхэг үлээгч аппаратыг хүлээлгэн өгсөн.<br>Мөн дүүргийн төсвийн 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Онцгой байдлын хэлтэст шаардлагтай гал унтраах, эрэн хайх 6 нэр төрлийн 53 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 3 удаа зохион байгуулахад аж ахуй нэгж материал ирүүлээгүй, худалдан авах ажиллагааны шатанд байна. | 100.0% |
| 1.3.4. Замын хөдөлгөөнд оролцогчдын замын хөдөлгөөний соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна. | 33 | Ерөнхий боловсролын сургуулиудад замын хөдөлгөөний мэдлэг олгох сургалтыг “Жолооч бэлтгэх” сургалтын байгууллагуудын замын хөдөлгөөний дүрмийн багш нартай хамтран бэлтгэгдсэн сургагч багшийг дадлагажуулан сургалт зохион байгуулах | 2024-2028 | Сургалтын тоо | 10 | 10 | | | | | | | | Хүүхдэд ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ оны 01 дүгээр сарын 24-ний өдөр нийслэлийн ерөнхий боловсролын 52, 15, 18, 34, Шинэ өнөөдөр сургуулиудад 43, 44, 45, 46, 47 дугаартай 23 зүйл бүхий албан мэдэгдлийг хүргүүлсэн. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгэмлэг” төрийн бус байгууллагатай хамтран цахилгаан хөдөлгүүртэй дугуй (Surron)-г унахад тавигдах шаардлага болон унадаг дугуй, скүүтэр, мопед унаж замын хөдөлгөөнд хэрхэн оролцох талаарх Замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 09 дүгээр сарын 24-ний өдөр Ерөнхий боловсролын 32, 52, Орчлон, Hobby, American school, Jet зэрэг 6 сургуулийн 600 сурагчдад зохион байгуулсан. Энэ онд 8 аж ахуй нэгж байгууллагын 292, ерөнхий боловсролын 15 сургуулийн 1854 эцэг, эх асран хамгаалагч нарт зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар сургалтыг үе шаттай зохион байгуулсан.. | 70.0% |
| | 34 | Зам тээврийн осол, зөрчил (тодорхой төрөл)-ийг бууруулах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, иргэд олон нийтэд чиглэсэн нөлөөлөл, сурталчилгааны ажил зохион байгуулах. | 2024-2028 | Нөлөөллийн арга хэмжээний тоо | 80 | 5 | | | | | | | | “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл худалдаа” эрхэлдэг “Апу ХХК”, “Витафит милк ХХК”-ийн түгээлтийн болон үйлчилгээний 43 жолооч нарт “Замын хөдөлгөөний дүрэм, журам, холбогдох эрх зүйн мэдлэг, олгох зорилгоор 1 цагийн сургалт, “Зорчигч тээвэр VI” ОНӨААТҮГ-ын 53 жолоочид “Замын хөдөлгөөний дүрэм”-ийн мэдлэг олгох сургалт тус тус зохион байгуулсан.“Замын хөдөлгөөн цагаан толгой” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд дүүргийн 25 цэцэрлэгийн 1150 хүүхдийг хамруулсан.<br>Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй “Цэмцгэр хэв маяг итгэл төрүүлнэ” нөлөөллийн аяны хүрээнд энэ оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 01 минут 30 секундийн уриалга рээл бэлтгэн “Ангараг хаалттай групп”-д байршуулж, 99 like, 7 сомент, 1018 хандалт авч, 01 дүгээр сарын 30, 02 дугаар сарын 10-ны өдрүүдэд “Авто радио 96.3”-тай хамтран 2 удаагийн 80 минутын мэдээлэл, ярилцлага хийсэн.<br>Хан-Уул дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Дүрмээ мөрдье” аяны хүрээнд нийт 16 төрлийн видео бичлэг хийж 1.650.000 хүний хандалт авсан. | 100.0% |
| | 35 | Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний ойг угтан Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хамтран сурталчилгааны ажил болон хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх ажил зохион байгуулах | 2025-2028 | Арга хэмжээ зохион байгуулсан ЕБСургуулийн тоо | 22 | 23 | 15.0 | | | | 15 | | | Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчний үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойг тохиолдуулан төлөвлөгөөт 15 ажил төлөвлөснөөс 14 ажил биелэгдэж төлөвлөгөөний хэрэгжилт 93,3 хувьтай биелсэн.<br>Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний анги, төрийн цэргийн байгууллага-6, ерөнхий боловсролын сургууль-15, хувийн хэвшлийн-1, нийт 22 байгууллагатай хамтран ажиллаж, нийт 2000 гаруй иргэдийг оролцуулан зохион байгуулсан. | 100.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн | | | | | | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг) Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | | |
| 1.3.5. Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжил олгох олон талт арга хэмжээг зохион байгуулж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлнэ. | 36 | Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу ээлжит цэрэг халалт, татлагын ажлыг жил бүр зохион байгуулах | 2025-2028 | Тоон даалгаврын биелэлтийн хувь | 68.2 | 90 | 90.0 | | | | 90 | | | Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/435, А/1315, дүүргийн Засаг даргын 2025 оны А/205, А/458 дугаар захирамжийн дагуу 2025 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 05, 10 дугаар саруудад зохион байгуулж Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн Зэвсэгт хүчин, Хилийн ба Дотоодын цэргийг нөхөн хангах тоон даалгаврыг нэгдүгээр ээлж 100 хувь, хоёрдугаар ээлж 69 хувьтай тус тус биелүүлсэн. | 85.0% |
| | 37 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй хээрийн дадлага сургуулийг зохион байгуулж, бие бүрэлдэхүүнийг бүрэн ирцтэй оролцуулж, орон нутгийн хамгаалалтын үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх | 2025-2028 | Орон нутгийн хамгаалалтын нөөц чадавхийн өсөлтийн хувь | - | 20 | 31.0 | | | | 31.0 | | | Сургалтад шаардагдах төсвийг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсөвт оруулж, холбогдох зардлыг батлуулан бэлтгэл ажлыг хангаж, дүүргийн Засаг даргын мн/05 дугаар захирамжийн дагуу Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг Зэвсэгт хүчний дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн 05 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд зохион байгуулсан. | 100.0% |
| | 38 | Цэрэг спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулах МУЗГҮАХХАХТ-1357 | 2025-2028 | Оролцсон хүүхдийн тоо | 201 | 210 | 25.0 | | | | 25.0 | | | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/162 дугаар захирамжийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг спортын "Дөл-2025" тэмцээнийг 04 дүгээр сарын 18-ны өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн материаллаг баазд түшиглэн зохион байгуулж 14 сургуулийн 182 сурагчид оролцсон. Шалгарсан 3 тасгийн бүрэлдэхүүнээс сонгон шалгаруулж Улсын аварга шалгаруулах цэрэг спортын тэмцээнд оролцуулж "Гутгаар байр" эзэлсэн. | 100.0% |
| Шаардагдах төсөв | | | | | | | 2,828.0 | - | - | - | 2,249.6 | 774.6 | - | | |
| **НЭГ.ТӨРИЙН АЛБАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ – 20 МИНУТЫН ХОТЫН ШИЛЖИЛТЭД ШААРДАГДАХ ТӨСӨВ** | | | | | | | **86,035.4** | **9,668.3** | **62,979.5** | **-** | **31,639.3** | **1,212.4** | **-** | | **92.6%** |
| **ХОЁР. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | | | | | | | | | | |
| **Санхүү, төсвийн зохицуулалт**<br>**2.1. Төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ил тод нээлттэй байдлыг сайжруулан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | |
| 2.1.1 Төсвийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, саналыг тусган боловсруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, үр дүнг иргэд, олон нийтэд ил тод мэдээлэж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг өндөржүүлнэ. | 39 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж, саналд үндэслэн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх | 2025-2028 | Саналын тоо | 99,453 | 100,000 | | | | | 25.0 | | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэд, олон нийтээс санал асуулга авах ажлыг 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийн хооронд "Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн систем (www.onhs.mof.gov.mn)", "ОНХС" аппликейшн болон "E-mongolia" цахим системээр дамжуулан зохион байгуулж, дүүргийн хэмжээнд нийт 131,197 санал ирүүлсэн.<br>Ажлын хэсэг, хороод хамтарч иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлж, Хан-Уул дүүргийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралд танилцуулж, 2026 оны төсөвт тусгуулах бэлтгэл хангаж ажиллаж байна. | 100.0% |
| | 40 | Хөрөнгө оруулалтын ажлын үе шатуудыг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд шилжүүлэх МУЗГҮАХХАХТ-483 | 2025-2028 | Хэрэгжилтийн хувь | | 50% | | | | | | | | Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг дэргэдэх хэлтэс, алба, хороодоос авч нэгтгэн боловсруулж, Төсвийн тухай хуулийн шаардлага хангасан батлагдсан зураг төсөвтэй 20 төсөл, арга хэмжээний саналыг улсын төсөвт тусгуулахаар, мөн батлагдсан зураг төсөвтэй 25 төсөл, арга хэмжээний саналыг нийслэлийн төсөвт тусгуулахаар төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн https://publicinvestment.gov.mn/ системд тус тус шивж, мэдээллийн санд хуулийн хугацаанд оруулсан. | 100.0% |
| | 41 | Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллагуудын холбогдох мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулах | 2025-2028 | Байршуулсан мэдээллийн тоо | 145 | 145 | | | | | | | | Хан-Уул дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчийн 23 сургууль, 42 цэцэрлэг, 9 орон нутгийн өмчит газар, 8 дэргэдэх байгууллага, 22 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 104 байгууллага мэдээлвэл зохих 12154 мэдээллээс хугацаандаа оруулсан 11849 мэдээлэл, хугацаа хоцроосон 305 мэдээлэл, огт оруулаагүй мэдээлэл байхгүй байна. Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалт 97,5 хувьтай байна. | 97.5% |
| | 42 | Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн тогтвортой байдлыг хангах | 2025-2028 | Хэрэгжилтийн хувь | 94.3 | 95.0% | | | | | | | | Орон нутгийн төсөвт 2025 оны 11 дүгээр сарын байдлаар орлого 536,845.1 сая төгрөг орох төлөвлөгөөтэйгөөс 460,651.0 сая төгрөг бүрдэж, өссөн дүнгээр 86 хувийн биелэлттэй байна | 90.0% |
| | 43 | Орон нутгийн төсвийн хэрэгжилтийг зохион байгуулж, төсвийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэлийг хөндлөнгийн байгууллагаар дүгнүүлэх | 2025-2028 | Аудитын дүгнэлт | "Өөрчлөлтгүй буюу Зөрчилгүй" дүгнэгдсэн. | "Өөрчлөлтгүй буюу Зөрчилгүй" дүгнэгдэнэ. | | | | | | | | Төсвийн тухай хуулийн 54.2-т "ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, төсөл, сан, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн тайланд хамруулна" гэж заасны дагуу Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн Э-ТАЙЛАН системд дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 88 байгууллагын 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Э-тайланд байгууллага бүрээр тулган шалгаж хүлээн авч дүүргийн нэгдсэн тайланг Нийслэл дэх төрийн Аудитын газраар шалгуулж зөрчилгүй буюу өөрчлөлтгүй дүгнэгдсэн. 2025 оны Аудитын дүгнэлт гаргуулах хугацаа болоогүй. | 100.0% |
| | 44 | Хувийн хэвшлийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг нэмэгдүүлэх | 2025-2028 | Төсөл, хөтөлбөрийн тоо | 4 | 1 | | | | | | | | Америкийн Нэгдсэн улсын Потомакийн их сургуультай 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Хан-Уул дүүргийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын мэргэшлийн түвшин, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор богино хугацааны мэргэшил дээшлүүлэх сургалтад албан хаагчдыг хамруулах, хамтарсан сургалт, семинар, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах чиглэлээр санамж бичиг байгуулсан. | 100.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн: Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг): Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 Хувийн хэвшил, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудын санал санаачилгыг дэмжин тулгамдсан асуудлыг шийдэх үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. | 45 | Төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор зорилтот иргэдэд чиглэсэн нөлөөллийн олон талт арга хэмжээ зохион байгуулах | 2025-2028 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 5.0 | 6 | | | | | 19.3 | | | Дүүргийн Улаан загалмайн хороо, Гүүд нейборс, Тайваны хүүхэд, гэр бүлийг дэмжих сан зэрэг байгууллагуудтай хамтран зорилтот иргэдэд чиглэсэн 5 арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал:<br>-Улаан загалмай хороотой хамтран томуу, томуу төст өвчний халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн сайн дурын идэвхтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж, сайн дурын 40 идэвхтнийг хамруулсан.<br>-Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор аливаа гамшиг ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг дадлага олгох, хүмүүнлэгийн эгнээнд элсүүлэх, хүнлэг энэрэнгүй нийгмийг хамтдаа бүтээх “Энэрэнгүй үйлсийн талд” аяныг зохион байгуулж 5000 гаруй ажилтан, албан хаагч, 300 сурагч8 30 иргэн хамруулан онцгой байдлын үед авах арга хэмжээний ойлголт мэдлэг олгосон.<br>-Гүүд нэйборс ТББ-тай хамтран өсвөр насныханд өөрийн хүссэн мэргэжлээ эзэмшиж, хүсэл мөрөөдөлд хүрэхэд нь дэмжлэг болох зорилготой “Сайн уу Амьдрал минь” хөтөлбөр хэрэгжүүлж, 72 хүүхдэд мэргэжил сонголтоо зөв хийхэд нь дэмжлэг үзүүлж, мэдлэг мэдээллээр хангасан.<br>-Хүүхэд хөгжлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр номын сангийн үйлчилгээнд 820, хичээлийн хоцрогдол нөхөх үйлчилгээнд 125 хүүхэд хамруулсан.<br>-Тайваний хүүхэд, гэр бүлийг дэмжих сангаас "Гэр хотхон" төсөлд 11 өрх хамруулснаас, 2025 оны 8 дугаар сард 12 дугаар хорооны иргэн 3 хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйд олгосон. | 83.3% |
| 2.1.3. Өмчийн бүртгэл, хяналтын менежментийг сайжруулах арга хэмжээ авч, өмч ашиглалтыг сайжруулан өмчийн үнэ цэнийг өсгөн үр ашгийг нэмэгдүүлнэ. | 46 | Орон нутгийн төсөвт байгууллагуудын өмчийн тооллогын тайланд холбогдох хяналт тавих МУЗГҮАХХАХТ-1065 | 2025-2028 | http://psp.gov.mn/ программд өмчийн хөдөлгөөнийг хугацаанд нь тайлагналтын хувь | - | 100% | | | | | | | | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврын дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хөрөнгийн мэдээллийг үе шаттайгаар иргэд, аж ахуйн нэгжид нээлттэй болгож, 2025 оны 10 дугаар сараас төрийн болон орон нутгийн өмчийн шинэ системийг бүрэн нэвтрүүлэн 2025 оны эхний гурван улиралд хийсэн хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөнийг шивж, мөн хуучин бүртгэлтэй байсан өмч хөрөнгийн фото зураг болон холбогдох мэдээллийн дүүргэлтийг шинэчлэх, сайжруулах ажлыг 2025 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн дотор багтаан зохион байгуулж дуусгасан. | 100.0% |
| 2.1.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан ногоон худалдан авалт болон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ. | 47 | Төсөл арга хэмжээний 5%-д ногоон худалдан авалт болон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжих | 2024-2025 | Ногоон болон дотоодын худалдан авалтын хувь | - | 5% | 42,711.0 | | | | | | | Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 73,982,026,100 (Далан гурван тэрбум есөн зуун наян хоёр сая хорин зургаан мянга нэг зуу) төгрөгийн төсөвт өртөгтэй 68 төсөл арга хэмжээ батлагдсан.<br>Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага болон худалдан авах тухай журмын дагуу 1 төсөл арга хэмжээг дотоодын үйлдвэрээс худалдан авалт хийсэн. Үүнд:<br>Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ХУДХААА/20250102022 дугаартай төсөл арга хэмжээн нийт 237,570,000 төгрөгийн төсөвтэй 2 багц төсөл арга хэмжээний 1 дүгээр багц 133,820,000, 2 дугаар багц 103,750,000 төгрөг 2 дугаар багц Анун ХХК-иас 91,072,520 төгрөгийн дотоодын худалдан авалт хийсэн. | 10.0% |
| Шаардагдах төсөв | | | | | | | 42,711.0 | - | - | - | 44.3 | - | - | | |
| **Жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал**<br>**2.2. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл,** | | | | | | | | | | | | | | | |
| 2.2.1 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, борлуулалтыг дэмжиж ажиллана. | 48 | Улс, Нийслэл, дүүрэг холбогдох байгууллагуудаас зохион байгуулж буй үзэсгэлэн худалдаанд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж боломжит хувилбараар дэмжин ажиллах | 2025-2028 | Үзэсгэлэн, худалдаанд оролцсон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо, дэмжлэг үзүүлсэн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | 15 | 5 | 25.0 | | | | | | | Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээг нь олон нийтэд сурталчлах зорилгоор дотоодын 19, олон улсын 2 нийт 21 удаагийн арга хэмжээнд 422 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн төлбөргүйгээр хамруулж, 1940 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулж нийт 834.3 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн. | 100.0% |
| 2.2.2.**“Хан-Уулд үйлдвэрлэв”** борлуулалтын төвийг байгуулж, төвийн үйл ажиллагаагаар дамжуулан гарааны бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана. | 49 | Борлуулалтын төвөөр дамжуулан үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулан, олон нийтэд сурталчлан таниулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллах | 2025-2028 | Дэмжин ажилласан үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | - | Борлуулалтын төвийг нээх байршлыг судалж, төсөл боловсруулан дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуул-сан | 30.0 | | | | | | | “Хан-Уулд үйлдвэрлэв” борлуулалтын төвийг байгуулахтай холбогдуулан 8 аж ахуйн нэгжээс талбайн хэмжээ, үнийн саналыг авч, боловсруулан "Бүтээгч-Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн хурлаар танилцуулж, борлуулалтын төвийг байгуулах санхүүжилтийг 2026 оны төсөвт тусгахаар шийдвэрлэсэн. | - |
| 2.2.3. Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжтай болж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана. | 50 | Худалдаа үйлчилгээ, аялал жуучлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, дотоодын аялал жуулчлалыг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах ажлыг зохион байгуулах | 2025-2028 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | - | 2 / 25% | 10.0 | | | | | | | Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамж бий болгох зорилгоор амралтын өдрийн худалдаа, төрөлжсөн худалдааг 3 байршилд зохион байгуулж нийт давхардсан тоогоор 80 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажилласан. | 100.0% |
| 2.2.4. Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, стандартыг хангуулна. | 51 | Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зөвлөн туслах хяналт шалгалт хийж, салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт уулзалт, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах үзэсгэлэн арга хэмжээ зохион байгуулж, иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах | 2025-2028 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | 3 / 100% | 3 / 25% | 10.0 | | | | | | | Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, эрүүл зохистой дадлыг хэвшүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилгоор 5 удаагийн сургалт, туршлага судлах арга хэмжээг Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, Премиум нексус ХК, Эйч ар консалтинг фирм ХХК-тай хамтран зохион байгуулсан. Сургалт, туршлага судлах арга хэмжээнд худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 409 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. | 100.0% |
| Шаардагдах төсөв | | | | | | | 50.0 | - | - | - | - | - | - | | |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн | | | | | | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг) | | | | | | | |
| | | | | | | | | Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | | |
| **Хүнс, худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуй**<br>**2.3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулах, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах зорилтыг дэмжин хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | |
| 2.3.1. Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 52 | Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах МУЗГҮАХХАХТ-857 | 2025-2028 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 2 | 50.0 | | | | 23.1 | | | Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэх зорилгоор 3 удаагийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>- Дүүргийн 13,14 дүгээр хорооны өрхийн тариалан эрхлэгчдийг нэмэгдүүлэх зорилгоор хөрс, боловсруулат, тариалалт, арчилгааны талаар сургалт зохион байгуулж, 29 төрлийн хүнсний ногооны үрийг 180 өрхөд олгон дэмжлэг үзүүлсэн. Мөн нарийн ногооны үрслэг бойжуулах арга, технологи, хөрс боловсруулах, таримал ургамлын өвчин, түүнтэй тэмцэх талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, 80 өрхөд 9 төрлийн хүнсний ногооны үр үрслэгээний дэмжлэг үзүүлсэн.<br>- Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран “MON-SHEP” төслийг 13 дугаар хороонд хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд “Тариад зарах” бус “Зарахын тулд тарих” арга барилд сурган, өрхийн орлогоо нэмэгдүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, төслийн гишүүдийг сонгох дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. | 100.0% |
| 2.3.2. Газар тариалан, хүлэмжийн аж ахуйн тариалалт, хадгалалт, борлуулалт, түгээлтийн сүлжээнд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангуулж хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 53 | хүнсний ногоо тариалж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад "Ургамал. ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд гарал, үүслийн гэрчилгээ" олгох, хяналт тавих ажлыг зохион байгуулж, хэрэглэгчдийг чанартай бүтээгдэхүүнээр хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах | 2025-2028 | Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгосон тариаланчийн тоо | 15 | 20 | 10.0 | | | | | | | Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:<br>-“Газар тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем”-ийн программ ашиглалтыг сайжруулах чиглэлээр газар тариалан, эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан.<br>-“Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн plant.mofa.gov.mn цахим систем”-д 59.1га тариалангийн талбай бүхий 7 аж ахуйн нэгж, 13 иргэний бүртгэлийг баталгаажуулсан.<br>-Төмс, хүнсний ногооны цахим гарал үүслийн гэрчилгээг 25 иргэн, ААН-ийн 13 нэр төрлийн 120.6тн хүнсний ногоонд олгосон.<br>Дүүргийн хэмжээнд 2025 онд хүлэмжийн тариалалтын талбайг 0.1га-аар нэмэгдүүлэхээр төлөвлөж, 3.3га талбайгаар тариалалтыг нэмэгдүүлсэн байна. | 100.0% |
| 2.3.3. Дүүргийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг ашиг шимийн чиглэлээр төрөлжүүлэн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 54 | Малын нөхөн үйлдвэрлэл, үржил, селекцийг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах МУЗГҮАХХАХТ-791 | 2025-2028 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 2 | 50.0 | | | | 31.7 | | | Малын нөхөн үйлдвэрлэл, үржил, селекцийг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд:<br>-Сүүний чиглэлийн үхэр сүргийн, үүлдэрлэг байдлыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор “Монтаримал ХХК”-иас цэвэр үүлдэрийн 3 хар тарлан үхэр худалдан авах ажлыг зохион байгуулсан.<br>-Сүүний үхрийн фермийн аж ахуй эрхлэгчдэд эрчимжсэн аж ахуйн стандарт, тугалын арчилгаа, маллагаа, тэжээллэг байдал, зохиомол хээлтүүлгийн ач холбогдлын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулж, 4 өрхийн 67 үнээнд зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээг хийх ажлыг зохион байгуулсан..<br>-Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд цэвэр болон сайжруулсан үүлдрийн 621 үнээ, цэвэр үүлдрийн 13 бухыг эзэмшүүлж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан. | 100.0% |
| 2.3.4. Мал, амьтны гоц халдварт, халдварт, шимэгчлэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт шинжилгээ хийх, оношлох, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, нутаг дэвсгэрийн мал, амьтны өвчлөлийн эрсдэлийг бууруулна. | 55 | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах МУЗГҮАХХАХТ-812 | 2025-2028 | Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдалтын хувь | 100% | 100% | 30.0 | | | | 75.6 | | | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:<br>Дүүргийн Засаг даргын 23 удаагийн захирамжаар импортоор оруулж ирсэн 1,777,000 үржлийн өндөг, 121 үржлийн адуунд хорио цээрийн дэглэм тогтоож, мал эмнэлгийн үзлэг шинжилгээнд хамруулж, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулсан.<br>Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 12 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 303235 мал, амьтныг хамруулж, хяналт тавьсан.<br>Мал амьтны шимэгчлэх өвчинтэй тэмцэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх, тархалт халдварлалтыг таслан зогсоох малд тарга тэвээрэг бүрэн авхуулах, малын гаралтай түүхий эдийн чанар, гарцыг сайжруулах зорилгоор 16800 малыг туулгалт, 13900 малыг угаалга, боловсруултанд хамруулсан.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт зүй бусаад хорогдсон 743 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 612700 м2 талбай бүхий бэлчээрийн талбай, хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, хяналт тавьж ажилласан. | 100.0% |
| 2.3.5 Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг хангуулж, иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ. | 56 | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж, хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах МУЗГҮАХХАХТ-812 | 2025-2028 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | 100% | 2 / 25% | 5.0 | | | | | | | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж, хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:<br>-Худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдад хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, эрүүл зохистой дадлыг хэвшүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилгоор 6 удаагийн сургалт, 21 удаагийн уулзалт зохион байгуулж, 857 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан.<br>-Худалдаа үйлчилгээний газруудад хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 29 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.<br>-Хүнсний аюулгүй байдал, холбогдох хууль тогтоомжийн талаар 5 төрлийн гарын авлага боловсруулж, худалдаа үйлчилгээний нийт 5870 иргэн, аж ахуйн нэгжид хүргүүлсэн. | 100.0% |
| 2.3.6 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна. | 57 | Хүнсний аюулгүй байдал, зохистой хэрэглээ, эрүүл баталгаат хүнс сонгох, зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах чиглэлээр иргэд, олон нийтэд сурталчлах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж ажиллах | 2025-2028 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | - | 1 / 20% | 5.0 | | | | | | | Хүнсний аюулгүй байдал, зохистой хэрэглээг дэмжих, эрүүл баталгаат хүнс сонгох мэдлэгийг нэмэгдүүлэх, зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах зорилгоор иргэд, олон нийтэд чиглэсэн 4 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 880 гаруй иргэн, малчин, албан хаагчдыг хамруулсан.<br>Мөн дүүргийн гэр хороолол бүхий хорооны 1000 гаруй иргэний дунд ундны ус хадгалах савны төрөл, хэрэглээний дадлын талаар санал асуулга зохион байгуулж, “Хуванцар савнаас татгалзъя” гарын авлагыг боловсруулан хүргэж, зориулалтын бус хуванцар сав ашиглахгүй байх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. | 100.0% |
| Шаардагдах төсөв | | | | | | | 150.0 | - | - | - | 130.4 | - | - | | |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн<br>Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг)<br>Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Тохижилт, ногоон байгууламж**<br>**2.4. Иргэд амарч, тухлах ногоон байгууламж бүхий тохилог орчинг байгуулж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | |
| 2.4.1 Иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн амарч, зугаалах, спортоор хичээллэх, чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөлийг хангасан, цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 58 | Тохижилт, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах | 2024-2028 | Шинээр байгуулсан цэцэрлэгт хүрээлэнгийн тоо | 6 | 2 | 2,722.8 | | | | 2,362.8 | | | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5, 10, 11, 13, 15, 19, 21, 22, 24 дүгээр хороодын 9 байршилд 2025 онд хэрэгжсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд нийтийн эдэлбэр газарт 4,271 м.кв ногоон байгууламжийг шинээр байгуулсан.<br>Мөн дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 21 дүгээр хороо, “Цэцэрлэгт хүрээлэн, спорт талбай, зам талбайн тохижилтын ажил 2 дугаар үе шат"-ны ажлын гүйцэтгэгчээр “Гарден сити” ХХК шалгарч, 1044 м.кв талбайд (44 машин) ус зайлуулах шугам сүлжээ бүхий авто зогсоол, чийрэгжүүлэлтийн талбай-552 м.кв, тоглоомын талбай-610 м.кв, гүйлтийн зам-1060 м.кв (600 метр), явган хүний зам-400 м.кв-ыг тус тус төлөвлөн 3000 м.кв талбайг зүлэгжүүлэх, 293 ширхэг (107 ширхэг гацуур, 186 ширхэг голт бор, гүйлс, буйлс) мод, сөөг тарьж ашиглалтад оруулсан.<br>“Туул голын эрэг дагуух тохижилтын ажил” төсөл, арга хэмжээ 22 дугаар хороонд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэгчээр мөн Гарден сити ХХК шалгарч 2025 онд I үе шатны ажлын хүрээнд 639.3 м.кв авто замын суурийн ажил, 1586.9 м.кв авто зогсоол, 700.6 м.кв явган хүний зам, 507 м.кв дугуйн зам, цахилгааны ажил болон авто замын 18 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажлууд дуусаж, 70 хувийн гүйцэтгэлтэйгээр он дамжин хэрэгжиж байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хорооны Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн 1.2 га талбайн засвар, шинэчлэлтийн ажлын зураг төслийг боловсруулсан. | 85.0% |
| 2.4.2. Орон сууц, гэр хорооллын дунд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд орчин үеийн шийдэл бүхий хүүхдийн тоглоомын талбай, спорт талбай байгуулна. | 59 | Стандартад нийцсэн спорт талбай, тоглоомын талбай байгуулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах | 2024-2028 | Шинээр байгуулсан тоглоомын болон спорт талбайн тоо | 7 | 6 | 1,597.9 | | 198.0 | | | 1,419.1 | | Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 200.0 сая төгрөгийн хөрөнгөөр 9-р хороо, Центрийн гудамжны баруун талд 625 м.кв ногоон байгууламж бүхий спорт болон тоглоомын талбайн тохижилтыг Эрчим төсөл ХХК 70% -ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна.<br>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5 төсөл арга хэмжээний хүрээнд 1, 2, 7, 10, 13, 19, 21, 25-р хорооны 10 байршилд спорт болон тоглоомын талбай засварлаж, шинэчлэхээр төлөвлөснөөс;<br>**Хэрэгжиж дууссан 7:**<br>1-р хороо, 2, 3-р байрны гадна,<br>2-р хороо, Хийморь хотхоны гадна,<br>3-р хороо, 56в байрны гадна,<br>10-р хороо, 62-р байрны гадна,<br>13-р хороо, 7-р хэсэг,<br>21-р хороо, Буянт-Ухаа 2 хороолол,<br>21-р хороо, Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэнд тус тус чийрэгжүүлэлт, спорт болон тоглоомын талбай.<br>**Зураг төсөл батлагдах шатанд 3:**<br>1-р хороо, 39, 40, 41, 42-р байрны 5х5 сагсан бөмбөгийн талбай,<br>7-р хороо, Жаргалант 18-р гудамжинд спорт талбай,<br>25-р хороо, Буянт-Ухаа 1 хорооллын тоглоомын талбайн засвар, шинэчлэлт.<br>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалттай 8 төслийн хүрээнд (1-10, 12, 13, 17, 19, 20, 21, 25) 17 хорооны 24 байршилд тохижилт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх, засварлаж, шинэчлэх зураг төсөл боловсруулахаас;<br>**2 төслийн хүрээнд 5 байршлын зураг төсөл хэрэгжиж дууссан:**<br>1. 12, 41, 71, 52-р сургуулийн гадна талбай,<br>2. Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсөв.<br>**1 төслийн хүрээнд 9 байршлын ажлын зураг төсөв боловсруулах шатанд:**<br>1, 6, 19, 20, 24-р хорооны 9 байршлын тоглоомын талбай, спорт талбайн тохижилт, засвар шинэчлэлтийн зураг төсөв<br>**4 төслийн хүрээнд 8 байршлын загвар зураг боловсруулах шатанд:**<br>1. 8-р хороо, ӨЭМТ-ийн гадна талбай,<br>2. 13-р хороо, 2б хэсгийн спорт талбай, 21-р хороо, Буянт-Ухаа 2 хорооллын 1019-р байрны гадна талбай,<br>3. 3-р хороо, 9а байр болон Ривер стоун хотхоны баруун талын тоглоомын талбай,<br>4. 17-р хороо, Оргил стар хотхоны баруун тал, 20-р хороо, 43-р байрны гадна, 25-р хороо Дөрвөн бэрх хотхоны тоглоомын талбайн загвар зураг төсөв<br>**1 төслийн хүрээнд 6 төсөл арга хэмжээ гэрээ байгуулах шатанд:**<br>Тохижилт бүтээн байгуулалтын зураг төсөв (Багц 3) төсөл арга хэмжээний хүрээнд 1, 2, 3, 9, 10, 12, 19 дүгээр хороонд 6 байршилд бичил цэцэрлэг, тоглоомын талбайн тохижилт, засвар, шинэчлэлтийн зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчээр “А И СИ Архитектс” ХХК шалгарч, гэрээ баталгаажих шатанд хэрэгжиж байна. | 80.0% |
| 2.4.3. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн эд хөрөнгө, тоглоомын талбай, спорт талбайг засварлаж, шинэчилж стандарт, орчны аюулгүй байдлыг хангуулна. | 60 | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн эд хөрөнгө, тоглоомын талбай, спорт талбайг засварлаж, стандарт, аюулгүй байдлын хангуулах | 2025-2028 | Засварлаж, шинэчлэн стандартад нийцүүлсэн тоглоомын болон спорт талбайн тоо | 117 | 20 | 1,652.5 | | | | 1,388.9 | | | Дүүргийн 1,2,3,7,8,10, 12,13,14,21,22 дугаар хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд эвдэрч гэмтсэн, засварлах шаардлагатай болон ашиглалтын хугацаа дууссан 25 хүүхдийн тоглоомын талбайн засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн: Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг): Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.4. Нийтийн эдэлбэр газар болон цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгүүдэд түшиглэн гоёл чимэглэлийн бут сөөг, олон наст цэцэг, ховор ургамлын хослол зохиомж бүхий цэцэрлэгт гудамж, талбайг үе шаттайгаар байгуулна. | 61 | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчилгааны ажлын хүрээнд цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгүүдэд гоёлын мод бут тарих, цэцгийн мандал байгуулах замаар хослол зохиомж бүхий цэцэрлэгт гудамж, талбайг байгуулах НЗДҮАХ-1.2.21 | 2025-2028 | Нэмэгдсэн цэцэрлэгт гудамж, талбайн хэмжээ (мкв) | 7033 | 5000 | 455.5 | | | | | | | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд арчилгаа, ногоон байгууламжийн арчлалт хариуцсан 12 байгууллага 54,180 ширхэг мод, бут сөөг тарьсан.<br>Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 15, 19, 24 дүгээр хорооны 6 байршилд 3 хэмжээст хийцлэл бүхий цэцэгт байгууламж байгуулах ажлын загвар зураг боловсруулах ажлыг зохион байгуулсан.<br>Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд цэцэг тарих, цэцгийн мандал байгуулах ажил төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилт хариуцсан 10 байгууллага, 2 ОНӨААТҮГ-аар нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 30 байршилд 375,200 гаруй цэцэг тариулж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгүүлж, хяналт тавьж ажилласан. Дүүргийн хэмжээнд нийт 4271 м.кв талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан. | 100.0% |
| | 62 | Мэргэжлийн байгууллагуудтай хамтарч нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтыг хийж гүйцэтгэх | 2025-2028 | Мэргэжлийн байгууллагуудад арчлалтыг хариуцуулсан нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, талбай (га) | 30.1 | 40 | 4,880.6 | | | | 3,303.0 | | | Ногоон байгууламжийн арчлалтыг хариуцсан мэргэжлийн хувийн хэвшлийн 10 байгууллага, ОНӨААТҮГ 2 байгууллага нь нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгийн 38.5 га, тусгай хэрэгцээний 14.5 га талбай, 11 бичил цэцэрлэгийн ногоон байгууламжийг агро технологийн 22 ажилбарын дагуу өдөр тутмын арчилгааг гүйцэтгэж, хөндлөнгийн хяналтыг "Бид байгаль элч" ТББ-р гүйцэтгүүлэн ажиллаж байна.<br>Дүүргийн Засаг даргын 2025 оны А/134 дүгээр захирамжаар 53.3 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэж, 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-аар нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, 5 хороо, 2 сургууль, 3 цэцэрлэгийн гадна талбай зэрэг нийт 34 байршилд 1820 ширхэг улиасны титмийг хэлбэржүүлэх ажлыг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажилласан. | 100.0% |
| 2.4.5 Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтлан иргэд, сургууль, цэцэрлэг, сууц өмчлөгчдийн холбоодод дэмжлэг үзүүлнэ. | 63 | Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог хангах чиглэлээр олон талт зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх (НЗДҮАХ-4.5.3) | 2025-2028 | Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ (мкв) | 7.9 | 8.1 | 374.5 | | | | 1,868.94 | | | Хан-Уул дүүрэг 2025 онд 104254 мкв буюу 10.4 га талбайгаар ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Үүнд:<br>Дүүргийн нутаг дэвсгэрийн 3 байршилд 12300 м.кв, нөхөн тарилт 10 байршилд 22810 м.кв, нийт 35110 м.кв талбайг зүлэгжүүлсэн.<br>"Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг хавар, намар 2 удаа зохион байгуулж, нийт 131,419 ширхэг мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.<br>Дүүргийн Засаг даргын 2025 оны А/103 дугаар захирамжийн дагуу "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-аар 1, 2, 15, 20 дугаар хороодын 10 байршилд 260,000 ширхэг нэг наст, гоёл чимэглэлийн цэцгийн мандал байгуулсан.<br>Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчилалт, нөхөн тарилт хариуцсан 12 байгууллага гудамж талбайн 30 байршилд 375,200 гаруй цэцэг тарьж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэж, хяналт тавьж ажилласан. | 100.0% |
| | 64 | Газарзүй мэдээллийн системд суурилсан ногоон байгууламжийн мэдээллийн санг ашиглалтад оруулж, мэдээллийн баяжилтыг сайжруулах | 2025-2028 | Мэдээллийн сангийн баяжилтын хувь | 70 | 100 | 112.4 | | | | | | | Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийн судалгаа, мэдээллийн сан хийх ажлын гүйцэтгэгчээр "Говийн улиас" ХХК шалгарч, ажлыг гүйцэтгэж байсан боловч ажлын чанар гүйцэтгэл хангалтгүйгээс 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гэрээг цуцалсан. | - |
| 2.4.6. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлж буй ойн төгөл байгуулах төсөл арга хэмжээг үргэлжлүүлж, тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | 65 | Айцын аманд ойн төгөл байгуулж буй талбайн хэмжээг нэмэгдүүлж, арчилж хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 2025-2028 | Ойн төгөл байгуулж, арчлалтад авсан талбайн хэмжээ (га) | 12.3 | 15 | 316.1 | | | | | | | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Айцын амны ойжуулалтын талбайд бүх нийтийн мод тарих аяныг 2 удаа зохион байгуулсан. Тус аяны хүрээнд 25 хороодын Засаг дарга нар, 27 дэргэдэх хэлтэс албадын 680 ажилтан албан хаагчид, нийслэлийн 7 байгууллагын 120 албан хаагчид нийт 800 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр улиас 1500, хайлаас 3000, шинэс 800, шар хуайс 3500 зэрэг 4 төрлийн 8,800 ширхэг мод тарьсан. Тус ойн төглийн арчлалт хамгаалалтыг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ -д хариуцуулан ажилласан. | 20.0% |
| 2.4.7 Иргэд, аж ахуйн нэгжүүдийн оролцоотой хур усыг хуримтлуулах, хөв цөөрөм байгуулах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгааны системийг нэвтрүүлж, зөөврийн усалгааг үе шаттайгаар хална. | 66 | Иргэд аж ахуйн нэгжүүдийн оролцоотой хур усыг хуримтлуулах, хөв цөөрөм байгуулах ажлыг холбогдох шатны байгууллагуудтай хамтарч ажиллах (МУЗГҮАХХТ-57) | 2025-2028 | Шинээр байгуулагдсан усалгааны систем бүхий хөв, цөөрмийн тоо | - | - | | | | | | | | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороонд Түр гол дагуу гадаргын усыг хуримтлуулах хөв цөөрмийн зураг төсөл боловсруулагдаж, 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр магадлал хийгдсэн.<br>Түргэний голын хөв цөөрөм нь 354.7 метр урт, 2 метрийн өндөр далантай, 11.48 мянган м.куб багтаамжтай, дунджаар 1 метрийн гүн усан мандлын талбай нь 1.6 га талбай байхаар төлөвлөгдсөн. | 50.0% |
| Шаардагдах төсөв | | | | - | | | 12,112.3 | - | 198.0 | - | 8,923.6 | 1,419.1 | - | | |
| **Агаар, хөрсний бохирдол**<br>**2.5. Агаар, хөрс бохирдуулагч эх үүсвэрийг иргэдийн оролцоотойгоор бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | |
| 2.5.1 Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг бусад эх үүсвэрт /төвлөрсөн дулаан, хий, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон бусад/ үе шаттай шилжүүлж, хатуу түлшний хэрэглээг бууруулж, амины сууцны дулаан алдагдлыг бууруулахад иргэд, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ. | 67 | Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг бусад эх үүсвэрт үе шаттай шилжүүлэх (МУЗГҮАХХТ-21) | 2025-2028 | Бусад эх үүсвэрийн халаалтад шилжсэн гэр хорооллын өрхийн тоо | | 1000 | | | | | | | | Агаарын бохирдолтой тэмцэх газрын үйл ажиллагаа дүүргийн Агаарын бохирдолтой тэмцэх тасаг, нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан 2025 оны 5 дугаар сарын 04 -07-ны өдрүүдэд "Дулаан байшин" өдөрлөгт гэр хорооллын 4,5,6,7,8,9,10,11,12,13,14,16,21,22,23 дугаар хороодын 680 гаруй иргэдийг оролцуулсан.<br>Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг бусад эх үүсвэрт шилжүүлэх ажлын хүрээнд 24 айл хийн халаалтад, 1 өрх цахилгаан халаалтад, 21 өрх шилжиж хатуу түлшний хэрэглээг бууруулж, амины сууцны 15 өрх хялбар шийдлээр дулаан алдагдлаа бууруулсан. | 10.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн | | | | | | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг) | | | | | | | |
| | | | | | | | | Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | | |
| 2.5.2. Иргэдийн оролцоотойгоор гэр хорооллын нүхэн жорлонгийн тоог үе шаттайгаар багасгаж, хөрсний бохирдлыг бууруулна. | 68 | Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | 2025-2028 | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо | 1828 | 1900 | | | | | | | | Дүүргийн хэмжээнд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тооллогын ажлыг зохион байгуулахад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй 3027 ширхэг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болж, 1199 ширхэгээр буурсан. | 100.0% |
| | 69 | Гэр хорооллын бүсэд нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг саармагжуулах арга хэмжээ авч ажиллах | 2025-2028 | Ариутгаж халдваргүйжүүлсэн нүхэн жорлон, бохирын цооногийн тоо, ширхэг | 17,000 | 15000 | 123.8 | | | | 247.6 | | | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/299 дүгээр захирамжийн дагуу гэр хорооллын айл өрхийн 10,380 нүхэн жорлон, 4959 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг "Түвшибилэг төгөлдөр" ХХК, "Баяндэмбэрэл" ХХК тус тус гүйцэтгэсэн. | 100.0% |
| 2.5.3. Арьс шир боловсруулах үйлдвэр, авто засвар, томоохон зах худалдааны төв зэрэг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс үүдэлтэй хүнд металлын бохирдлыг бууруулна. | 70 | Хөрсний бохирдлын судалгаа хийж, бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн гудамж, талбайг ариутгаж, халдваргүйжүүлэх МУЗГҮАХХАХТ-999 | 2025-2028 | Ариутгаж халдваргүйжүүлсэн талбай, м.кв | 357000 | 300000 | 200.0 | | | | 137.8 | | | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/152 дугаар захирамжийн дагуу 25 хороодын нийтийн эзэмшлийн бохирдол ихтэй, ариутгах шаардлагатай гудамж, зам талбай, хогийн цэг, хүүхдийн тоглоомын талбай, далан гуу жалганы нийт 230,000 м.кв талбайг мэргэжлийн байгууллагаар ариутгаж халдваргүйжүүлсэн. (Гүйцэтгэгч "Хансудар" ХХК)<br>Дүүргийн хэмжээнд бохир усны шугам сүлжээ бөглөрч бохир хальсан гудамж талбайн 15 байршлын 50,500 м.кв талбайг мэргэжлийн байгууллагаар ариутгаж халдваргүйжүүлсэн. | 100.0% |
| 2.5.4. "Эмээлт эко аж үйлдвэрийн парк"-т арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэж, үйлдвэрийн бүс орчмын хөрсний бохирдлыг арилгах, чөлөөлөгдсөн талбайд зам талбай ногоон байгууламж, нийгмийн дэд бүтцийн байгууламж төлөвлөн байгуулах цогц арга хэмжээг талуудтай хамтран эхлүүлнэ. | 71 | Арьс ширний үйлдвэрүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран нүүлгэн, шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэх (МУЗГҮАХХТ-82) | 2026-2028 | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | - | | | | | | | | "Эмээлт эко аж үйлдвэрийн парк"-т арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх ажлын хүрээнд Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэт үйлдвэрийн хэсгийн 30.27 га талбайг дахин төлөвлөх барилгажилтын зураг төслийг боловсруулж байна.<br>Хот байгуулалт, хотын стандартын газар, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК хамтран 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр нийслэлийн удирдлага, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, МУИС, ШУА-ын Газарзүй Геоэкологийн хүрээлэн, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн сургуулийн эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулан "Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны үйлдвэрийн бүсийн хөрс, усны бохирдлыг саармагжуулах, нөхөн сэргээх нь" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр үйлдвэрийн бүс орчмын бохирдлыг бууруулах аргачлал, нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах чиглэлээр судалгааны үр дүнг хэлэлцэж, талууд санал солилцон үйлдвэрийн бүсийн байгаль орчныг нөхөн сэргээх аргачлал, төлөвлөгөө боловсруулж хамтран ажиллахаар харилцан тохиролцсон. | 70.0% |
| 2.5.5. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ. | 72 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх | 2025-2028 | Нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ (га) | - | 2 | 90.0 | | | | 19.7 | | | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/90, дүүргийн Засаг даргын 2023 оны А/151, 2025 оны 207 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч, тээвэрлүүлэгч аж ахуй нэгжүүдийн тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллахад тээвэрлэлтийн хариуцлагын гурвалсан гэрээ байгуулсан 25 аж ахуй нэгжийн давхардсан тоогоор 9954 тээврийн хэрэгслээр 238,896 тн хайрга, дайрга тээвэрлэгдсэнийг бүртгэн хяналт тавьж ажилласан.<br>Хяналтаар бүтээлэггүй 115, даац хэтрүүлэн ачилт хийсэн 64, маршрутын бус замаар тээвэрлэлт хийсэн 48, устай хайрга ачин, замаар ус гоожуулсан 21 тээврийн хэрэгслийн зөрчлийг илрүүлж, торгуулийн арга хэмжээ тус тус тооцуулан ажилласан.<br>НБОГ-н даргын А/149 дүгээр тушаалаар 2025 оны нөхөн сэргээлтийг хянаж хүлээн авах ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сард дүүргийн хэмжээнд нөхөн сэргээлтийг хүлээн авахаар бэлтгэл ажил хангаж байна. | 100.0% |
| 2.5.6. Гэр хорооллын бүсийн ус түгээх цэгийг нэмэгдүүлж, хуучин ус түгээх байрыг засварлан ухаалаг төхөөрөмж суурилуулж хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 73 | Шаардлагатай байршлуудад ухаалаг төхөөрөмж бүхий ус түгээх цэгүүдийг шинээр байгуулж, хүртээмжийг нэмэгдүүлэх | 2024-2028 | Ухаалаг төхөөрөмж бүхий ус түгээх цэгийн тоо | 5 | 17 | 200.0 | | | | 369.0 | | | Дүүргийн төсвийн 380.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн "Шинээр гүний худаг байгуулах ажил (13, 14 дүгээр хороо)" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр "Баялаг говь" ХХК ажиллаж, 13, 14 дүгээр хороонд 6 байршилд шинээр смарт ажиллагаатай гүний худаг барьж, ашиглалтад оруулсан.<br>Нийслэлийн төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Эйч Ти Эл" ХХК дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хороонд нийт 11 гүний худгийн барилгыг засварлаж, ухаалаг төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэж дууссан. Байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллах шатанд байна. | 100.0% |
| 2.5.7. Хот нийтийн аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үргэлжлүүлж, хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийнэ. | 74 | Хот нийтийн аж ахуйн шаардлагатай дэвшилтэт технологи бүхий машин, механизм, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үргэлжлүүлэх | 2024-2028 | Шинээр нийлүүлсэн машин тоног төхөөрөмжийн тоо | 15 | 22 | 1,000.0 | | | | 1,000.0 | | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Хог төвлөрүүлэх цэгийн өргөж буулгадаг хогийн сав, хог буулгаж ачих крантай автомашин худалдан авах" төсөл арга хэмжээний хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 25 ширхэг хогийн сав суурилуулахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэгч "Мөнх инспайринг" ХХК 2025 оны 12 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Дээрх төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр ачигч нарын хөдөлмөрийг хөнгөвчилж, цаг хугацааг хэмнэнэ. | 100.0% |
| 2.5.8. Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах төсөл хэрэгжүүлнэ. | 75 | Айл өрхүүдийн төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийг дэвшилтэд технологийн дагуу ариутгаж халдваргүйжүүлэх | 2024-2028 | Хэрэгжилтийн хувь | 247,602.0 | 100 | | | | | | | | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/299 дүгээр захирамжийн дагуу гэр хорооллын айл өрхийн 10,380 нүхэн жорлон, 4959 бохирын цооногийг био бактерийн аргаар ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг "Түвшибилэг төгөлдөр" ХХК, "Баяндэмбэрэл" ХХК тус тус гүйцэтгэсэн. | 100.0% |
| 2.5.9. Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ. | 76 | Энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх үйл ажиллагааг тогтмолжуулж, менежментийг сайжруулах | 2024-2028 | Тээвэрлэх хог хаягдал, мян.тн | | 150000 | 16,221.1 | | | | 20,000.0 | | | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/77 дугаар захирамжийн дагуу 1, 2, 3, 19, 20, 23 дугаар хороодын энгийн хог хаягдал тээвэрлэлтийг "Эко хотын тээвэр" ААТҮГ, 4, 5, 6, 7, 8, 24 дүгээр хороодын энгийн хог хаягдал тээвэрлэлтийг "Хан-Эко тээвэр" ААТҮГ, 9, 10, 12, 13, 14, 16 дүгээр хороодын хог тээвэрлэлтийг "Тохижилт, үйлчилгээний төв" ОНӨААТҮГ, 11, 15, 17, 18, 22 дугаар хороодын энгийн хог хаягдал тээвэрлэлтийг "Хан-Уул Агро" ОНӨААТҮГ тус тус хариуцан ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 41,406 рейсээр 173,577.424 тонн хог хаягдлыг тээвэрлэн Морингийн төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн байна. | 100.0% |

| Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023-2024 он | 2025 он хүрэх түвшин, үр дүн | | | | | | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Тухайн жилд батлагдсан төсөв | төсвийн эх үүсвэр (сая төгрөг) | | | | | | | |
| | | | | | | | | Улс | Нийслэл | НОНХС | Дүүрэг | ДОНХС | Бусад, гадаадын зээл тусламж | | |
| | 77 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол сайжруулж, хяналт тавих | 2024-2028 | Арчлалт хамгаалалтад авсан нийтийн эзэмшлийн талбайн хэмжээ. | | 3.8 | 26,903.8 | | | | 20,000.0 | | | Дүүргийн нийтийн эзэмшлийн нийт 3,868,120 м.кв зам талбайн цэвэрлэгээг 4 ОНӨААТҮГ, ХАА-р шалгарсан 10 хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдал, цас мөсийг тухай бүр ачиж тээвэрлэж, цэвэр орчныг бүрдүүлж ажиллаж байна. Хөндлөнгийн хяналтыг "Хотын хөгжлийг дэмжих шинэ тосгон холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэн, сар бүрийн гүйцэтгэлээр санхүүжилт олгосон. | 100.0% |
| Шаардагдах төсөв | | | | | | | 44,738.7 | - | - | - | 41,774.1 | - | - | | |
| **Эрүүл мэнд, спорт**<br>**2.6. Олон нийтийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | | | | | | |
| 2.6.1. Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ. | 78 | Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг өсвөр насны хүүхдүүдийн дунд зохион байгуулах | 2025-2028 | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо | - | 9000 | 1.0 | | | | | | | Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолын хүрээнд иргэдэд олон нийтэд чиглэсэн халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх 13 сэдвээр 71 удаагийн сургалт зохион байгуулж 17,549 иргэнийг хамруулсан.<br>"Дэлхийн амны хөндийн эрүүл мэндийн өдөр", “Хорт хавдраас сэргийлэх дэлхийн өдөр”, "Дэлхийн эрүүл мэндийн өдөр”, “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр", "Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх аян", "Өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих аян" зэрэг 2 аян, 4 өдөрлөгт, нийт 976 иргэнийг хамруулан зохион байгуулсан.<br>Хиймэл оюун ухаанд суурилсан AI технологи ашиглан https://www.facebook.com/, khuemt.hospital health.promotion.center цахим хуудсаар Халдварт өвчийн судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх чиглэлээр гаргасан 52 төрлийн зурагт хуудас байршуулж 12,290 хандалт авч, "Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх үзлэг эсийн шинжилгээ", “Шүд угаалтын аварга“, "Угаарын хийн эрсдэлээс сэргийлье", "Ахмадын эрүүл мэндийг дэмжих", "Өсвөр үеийн өсөлт хөгжлийн үнэлгээ" сэдэвт богино хэмжээний бичлэгийг нийт 100,000 гаруй иргэдэд хүргэж хандалт авсан. | 100.0% |
| 2.6.2.Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийг бууруулна. | 79 | Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэгт иргэдийн оролцоо, хамрагдалтыг нэмэгдүүлэх МУЗГҮАХХАХТ-387 | 2025-2028 | Хамрагдалтын хувь | 47 | 50 | | | | | | | | Хан-Уул дүүргийн нийт хүн амын тоо 2024 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн эрүүл мэндийн статистик мэдээллээр өмнөх оноос 15,211 хүн амаар буюу 5.8% хувиар өсөж, эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамрагдвал зохих нийт иргэдийн тоо 273,398 болж нэмэгдсэн. 2025 оны эхний 5 сарын байдлаар эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд нийт 130410 иргэн буюу 47.7% нь хамрагдсан бөгөөд насны ангиллаар авч үзвэл;<br>0-5 нас 36,326 хүүхдээс 21,885 буюу 60.2%,<br>6-17 нас 71,613 хүүхдээс 44,756 буюу 62.5%,<br>18-30 нас 36,459 хүүхдээс 9,770буюу 27%,<br>31-45 нас 70,393 хүнээс 22,568 буюу 32%,<br>46-60 нас 37,440 хүнээс 18,891 буюу 50,5%,<br>61 дээш нас 21,167 иргэнээс 12,540 буюу 59% хамрагдсан байна. | 100.0% |
| | 80 | Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулах МУЗГҮАХХАХТ-396 | 2025-2028 | Артерийн даралт ихсэх өвчний ЭИХ-ын хувь | 78 | 78 | | | | | | | | 2025 оны эхний 10 сарын байдлаар артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдах 162,891 иргэнээс 114,023 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 70 хувийн хамрагдалттай байна. | 90.0% |
| | | | | Чихрийн шижин ЭИХ-ын хувь | 83 | 83.5 | | | | | | | | 2025 оны эхний 10 сарын байдлаар чихрийн шижин 2-р хэв шинж өвчний эрт илрүүлэгт хамрагдах 108,192 иргэнээс 83,962 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 78 хувийн хамрагдалттай байна. | 93.0% |
| | | | | Умайн хүзүүний хавдрын ЭИХ-ын хувь | 39.8 | 40 | | | | | | | | 2025 оны эхний 10 сарын байдлаар умайн хүзүүний хавдрын өвчний эрт илрүүлэгт хамрагдах 60,677 иргэнээс 52,940 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 87 хувийн хамрагдалттай байна. | 100.0% |
| | | | | Хөхний хавдрын ЭИХ-ын хувь | 79.8 | 80 | 83.0 | | | | | | | 2025 оны эхний 10 сарын байдлаар умайн хүзүүний хавдрын өвчний эрт илрүүлэгт хамрагдах 15,547 иргэнээс 12,222 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 80 хувийн хамрагдалттай байна. | 100.0% |
